

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн албаны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 93¹ дугаар зүйл. “Цагдаагийн хөгжлийн сан.”

93¹.1.Цагдаагийн хөгжлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.2, 6.1.3-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

93¹.1.1.цагдаагийн баг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийн Засгийн газраас тогтоосон хэсэг;

93¹.1.2.энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн байгууллагаас ашиглуулж байгаа үндсэн болон туслах зэвсэг, техник, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөхөн төлбөр;

93¹.1.3.энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийн нөхөн төлбөр.

93¹.2.Энэ хуулийн 93¹.1-д заасан сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

93¹.2.1.цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх;

93¹.2.2.цагдаагийн байгууллагын зэвсэг, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх, сургалтын материаллаг нөөцийг бэхжүүлэх;

93¹.2.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх;

2 дугаар зүйл. Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “1 жил 4 сараар” гэсний дараа “энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн зургаан сар тутмыг найман сараар,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө